



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2020 он 05  
сарын 14 өдөр

Дугаар 35-1/  
79

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

“Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ





МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он 05 дугаар  
сарын 11-ны өдөр

Дугаар 135/1300

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тов тогтоолгох тухай

“Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн тул уг тогтоолын төслийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.Оюун-Эрдэнэ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

205693



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@mojha.gov.mn,  
Вэбсайт: www.mojha.gov.mn

2020. 05. 14 № 44/1969

таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД  
Ч.УЛААН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



**151607065**

Doc.yam a5.2020



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2020.05.14 № 6/3269  
танаи 2020.05.14 № 01/1838 -т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД  
Ч.УЛААН ТАНАА

“Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцлаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт зааснаар тогтоолын төслийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

9764 00599

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлд:

“ХҮІ. ХЭЛЭЛЦСЭН нь: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## “ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг.Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловруулах болсон үндэслэл, шаардлага**

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 2.1.16-д “малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах”, 2009 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын 3.1.8-д “малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээ авах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.3-т “2020 онд нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэх” гэж заасан.

### 1.2.Практик шаардлага

Коронавируст халдвар /COVID -19/-ын цар тахлын үед малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах чиглэлээр УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолыг баталсан билээ.

Үг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас 2020 оны 05 сарын 06-ны өдөр тогтоол гаргаж малчин өрхөд 2019 оны мал тооллогын малчны А дансны мэдээллийг үндэслэн ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартын дагуу тооцож, нэг килограмм тутамд 20000 /хорин мянга/ төгрөгийн урамшууллыг малчны дансанд шилжүүлэхээр тусгаж урамшуулалд шаардагдах 200.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлээд байна.

Улсын хэмжээгээр 2019 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан

дүнгээр 71.0 сая толгой мал, үүнээс 330 сум, нийслэлийн 6 дүүрэгт нийт 29.3 сая ямаа тоологдсон.

2019 оны статистикийн мэдээгээр нийт 233,317 малтай өрх, үүнээс 171,610 малчин өрх, 61,707 мал бүхий этгээд байх ба мал бүхий этгээдэд 2.9 сая ямаа тоологдсон байна.

Үндэсний статистикийн хорооноос малчин, мал бүхий этгээдэд А дансыг тус тусад нь хөтөлж байгаатай нийцүүлэх, мал бүхий этгээд урамшуулалд хамрагдахгүй үлдэж, тэгш бус байдал үүсэхээс сэргийлэх зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 3 дахь заалтын 3-т “малчин өрх” гэснийг “малчин, мал бүхий этгээд” гэж өөрчлөх шаардлагатай байна.

“Малчин”, “мал бүхий этгээд” гэсэн нэр томъёог Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай зэрэг хуулиудад тодорхойлсон агуулгаар хэрэглэсэн ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг ойлгохоор, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.6-д “мал бүхий этгээд” гэж малчин өрхөөс бусад мал өмчилж байгаа хувь хүнийг ойлгохоор тус тус заасныг үндэслэсэн болно.

### **Хоёр.Тогтоолын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 заалттай байна. 1 дэх заалтад Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолд оруулах өөрчлөлтийн талаар тусгах ба 2 дахь заалтад дагаж мөрдөх хугацааны талаарх зохицуулалтыг тусгана.

Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 3 дахь заалтын 3-т “малчин өрх” гэснийг “малчин, мал бүхий этгээд” гэж өөрчлөлт оруулахаар тогтоолын төслийг боловсруулна.

Малын генетик нөөцийн тухай хуульд заасны дагуу “малчин, мал бүхий этгээд” гэдэгт зөвхөн хувь хүнийг хамаарулахаар тооцсон болно.

### **Гурав.Тогтоолын төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн**

Тогтоолын төсөл батлагдсанаар малчнаас гадна мал бүхий этгээд урамшуулал авах боломжтой болж, тэгш бус байдал үүсэхээс сэргийлэх ба Улсын Их Хурлын тогтоол нэг мөр хэрэгжих боломжтой болно.

### **Дөрөв.Тогтоол гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй ба тогтоолын төслийг дагалдан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

## “ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах чиглэлээр УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолыг баталсан билээ.

Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 05 сарын 06-ны өдрийн хуралдаанаас тогтоол гаргаж малчин өрхөд 2019 оны мал тооллогын малчны А дансны мэдээллийг үндэслэн ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартын дагуу тооцож, нэг килограмм тутамд 20000 /хорин мянга/ төгрөгийн урамшууллыг малчны дансанд шилжүүлэхээр тусгаж урамшуулалд шаардагдах 200.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлээд байна.

Улсын хэмжээгээр 2019 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр 71.0 сая толгой мал, үүнээс 330 сум, нийслэлийн 6 дүүрэгт нийт 29.3 сая ямаа тоологдсон.

2019 оны статистикийн мэдээгээр нийт 233,317 малтай өрх, үүнээс 171,610 малчин өрх, 61,707 мал бүхий этгээд байх ба мал бүхий этгээдэд 2.9 сая ямаа тоологдсон байна.

Үндэсний статистикийн хорооноос малчин, мал бүхий этгээдэд А дансыг тус тусад нь хөтөлж байгаатай нийцүүлэх, мал бүхий этгээд уг тогтоолын дагуу олгогдох урамшуулалд хамрагдахгүй үлдэж, тэгш бус байдал үүсэхээс сэргийлэх зорилгоор Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 3 дахь заалтын 3-т “малчин өрх” гэснийг “Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд” гэж өөрчлөх шаардлагатай байна.

Тогтоолын төслийг боловсруулахдаа Малын генетик нөөцийн тухай, Мал, амтны эрүүл мэндийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудад тодорхойлсон нэр томъёог хэрэглэсэн ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг ойлгохоор, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.6-д “мал бүхий этгээд” гэж малчин өрхөөс бусад мал өмчилж байгаа хувь хүнийг ойлгохоор тус тус заасныг үндэслэсэн болно.

Иймд Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолын 3 дахь заалтын 3-т “малчин өрх” гэснийг “Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд” гэж өөрчилсүгэй.
- Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

**“ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ  
УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ**

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан
2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Батхүү
3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батмөнх
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал